

СТОУС-ын нэвтрэлтийг цэгнэхүй

Л. Дондог¹

Хураангуй

Монгол улсад Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль анх 1993 онд батлагдсанаас хойшхи 24 жилийн хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлан гаргалтын байдал СТОУС-д хэр нийцэж буйг судаллаа. Судалгаанаас үзэхэд СТОУС-ын нэвтрэлт хангалтгүй бөгөөд түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, сайжруулах арга замыг эрэлхийлсэн болно.

Түлхүүр үгс: СТОУС, НББОУС, үндэсний стандарт, НББ-ийн тухай хууль

Анх 1993 онд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль батлагдаж мөрдөгдсөнөөс хойш Монгол улсын хөгжлийн түнш орон байгууллагуудын дэмжлэг, Сангийн яамны удирдлага, мэргэжлийн төрийн бус байгууллагын оролцоотойгоор их ажил амжуулсан байна. Өнгөрсөн 24 жилд нягтлан бодогчдыг олон улсын стандарт, гарын авлагаар хангах зорилгоор хийсэн ажлыг товч өгүүлэе. НББОУС 1996, СТОУС 2003, СТОУС 2010-ыг бүхэлд нь орчуулж 1998, 2003, 2012, 2014 онуудад хэвлэсэн байна. Мөн 2014 онд СТОУС 10, СТОУС 11, СТОУС 12, СТОУС 13-ыг орчуулжээ. СТОУС-ын хэрэглээний тайлбарыг 2009 болон 2014 онуудад ММНБИ-ээс эрхлэн гаргажээ. ЖДААН-ийн СТОУС 2009-ийг 2010 онд орчуулсан байна. Сангийн Яам 1995 оноос хойш СТОУС-ыг хэрэглэх аргыг тусгасан олон аргачлал, заавар, журам гаргажээ.

2014 онд Сангийн Яамнаас гаргасан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”, “Нягтлан бодох бүртгэлийн дансны жишиг жагсаалт” нь СТОУС-ын агуулгыг тайлбарласан, мөн ашиглах аргыг тусгасан чухал гарын авлага болсон байна. “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”-т СТОУС-ыг дараах долоон бүлэгт хувааж хэрэглэх аргыг тайлбарласан байна.

Энэ заавар нь СТОУС-д нийцсэн үндэсний стандарт гэж үзэж болохоор бичиг баримт болсон байна.

Мөн Сангийн Яам дангаараа болон бусад төрийн байгууллагатай хамтран дараах нягтлан бодох бүртгэлийн багц заавар, журмыг баталжээ. Үүнд:

- Нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх заавар, 2015 он;
- Үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх

¹ Монгол улсын гавъяат эдийн засагч, доктор, профессор.
E-mail: l_dondog@yahoo.com

- этгээдэд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн заавар (багц журам), 2015 он;
- Банкны нягтлан бодох бүртгэлийн заавар (багц журам), 2015 он;
 - Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх, цэвэр хөрөнгийг үнэлэх заавар (багц журам), 2015 он;
 - Кастодианы санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх заавар (багц журам), 2015 он;
 - Хадгаламж зээлийн хоршооны нягтлан бодох бүртгэлийн заавар (багц журам), 2012 он.

Сангийн Яам 2016 онд дараах гурван үндэсний стандартыг баталсан байна. Үүнд:

- Хайгуул болон олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн стандарт,
- Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт,
- Барилгын гэрээний орлого ба зардлын нягтлан бодох бүртгэлийн стандарт.

Дээрх үндэсний стандартууд нь СТОУС-тай нийцсэн гэж үзэж болохоор байгаа юм. Гэхдээ нягтлан бодох бүртгэлийн хүрээнд үйлчилдэг бусад заавар, журмыг тухайн үеийн СТОУС-д нийцүүлэн боловсруулсан тул одоогийн нөхцөлд нийцүүлэн сайжруулж, шинэчлэх зайлшгүй шаардлага гарч байгаа нь зүйн хэрэг билээ.

Аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодогчид Сангийн яамнаас гаргасан дээрх хагас хугас дурьдсан стандарт, заавар, журмыг бүгдийг судлаад ашигласан бол өдийд СТОУС бүрэн нэвтэрсэн байж болохоор байжээ гэсэн дүгнэлт гарч байна. Гэвч бодит байдал ямар байгааг авч үзье.

Хүснэгт 1. СТОУС-т нийцсэн тайлан гаргадаг байдал

Асуулт	Нийт ААН		Том ААН	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
1. СТОУС-д нийцүүлдэг	183	56.5	134	60.9
2. СТОУС-д нийцүүлэхийг хичээдэг боловч зарим СТОУС-ыг мөрдөж чаддаггүй	110	34.0	72	32.7
3. Зөвхөн татварын зорилгоор санхүүгийн тайлан бэлтгэдэг	31	9.5	14	6.4
Дүн	324	100.0	220	100.0

Тайлбар:

1. Эх сурвалж: Дэлхийн банк "СТОУС-ын нэвтрэлт" судалгааны тайлан, 2017 он.
2. "Хариулах боломжгүй" гэсэн хариулт өгсөн 38 компанийг тооцоонд оруулаагүй.
3. Товчилсон үгийн тайлбар:
 - Нийт ААН - судалгаанд оролцсон нийт аж ахуйн нэгж
 - Том ААН - судалгаанд оролцсон том аж ахуйн нэгж

Энэ судалгаанаас үзэхэд, судалгаанд оролцсон нийт аж ахуйн нэгжийн 56.5 хувь, түүний дотор том аж ахуйн нэгжийн 60.9 хувь нь СТОУС-д нийцсэн санхүүгийн тайлан гаргадаг байна.

СТОУС-д нийцсэн санхүүгийн тайлан гаргахыг хичээдэг боловч зарим стандартыг мөрдөж чаддаггүй байгууллага нийт аж ахуйн нэгжийн 34.0 хувийг эзэлдэг ажээ. Зарим СТОУС-ыг ашиглаж чадахгүй байгааг зах зээл, үнийн мэдээлэл хомс гэх мэт шалтгаанаар

тайлбарладаг байна.

СТОУС-ыг мөрддөггүй, зөвхөн татварын зорилгоор санхүүгийн тайлан бэлтгэдэг компани 31 буюу нийт аж ахуйн нэгжийн 9.5 хувийг эзэлдэг байна. Харин судалгаанд оролцсон компанийн 6.4 хувийг эзэлдэг 14 том аж ахуйн нэгж СТОУС-ыг мөрддөггүй гэж хариулсан нь анхаарал татах асуудал юм.

Сангийн Яам 2011 онд СТОУС-ын нэвтрэлтийн байдалд судалгаа хийсэн байдаг. Энэ судалгааны дүнг харьцуулж үзье.

Хүснэгт 2. СТОУС-ын нэвтрэлтийг 2011, 2017 оноор зэрэгцүүлсэн байдал

	Бүрэн нэвтрүүлсэн	Хагас нэвтрүүлсэн	Огт нэвтрүүлээгүй	Нийт
2011 оны НББ-ийн улсын үзлэгийн дүнгээр* (үзлэгт хамрагдсан ААН-ийн дүнд эзлэх хувь)	42.0%	37.0%	14.0%	100%
2017 оны түүвэр судалгаагаар (Судалгаанд хамрагдсан ААН-ийн дүнд эзлэх хувь)	56.5%	34.0%	9.5%	100%

* Эх сурвалж: 2011 оны НББ-ийн улсын үзлэгийн дүн мэдээ, Сангийн Яам.

Энэ судалгаанаас үзэхэд 2011 оноос хойш 5 жилийн хугацаанд судалгаанд хамрагдсан нийт аж ахуйн нэгжийн дотор СТОУС-ыг бүрэн нэвтрүүлсэн аж ахуй нэгжийн хувийн жин 14.5 нэгжээр өссөн буюу жилийн дундаж хурд 2.9 хувь болж байна. Хэрэв ийм хурдаар явбал СТОУС-ын бүрэн нэвтрэлт 15 жилээр сунжрах буюу 2032 он хүртэл үргэлжлэх хэрэг. Анх 1993 оноос олон улсын стандартын нэвтрэлтийн тухай ярьж эхэлснээс хойш 24 жил өнгөрчээ. Эхний жилүүдэд танин мэдэх, туршилтын, сургалтын гэх мэт олон шалтгаанаар нэвтрэлт удаан байсан нь ойлгомжтой.

2001 онд “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуульд шинэчилсэн найруулгын хэмжээний өөрчлөлт оруулж, түүнээс хойш төрөөс үлэмжхэн арга хэмжээ авсан юм. Гэтэл төрөөс хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн яагаад бага байгаагийн шалтгааныг судалж үзэхэд, нэгдүгээрт төрийн зохицуулагч байгууллагуудын ажлын уялдаагүй байдал, хоёрдугаарт нягтлан бодогчдын мэдлэг чадвар хангалтгүй байгаа гэсэн хоёр сөрөг хүчин зүйл нөлөөлж байлаа. Үүнийг арай тодорхой өгүүлье.

Аж ахуйн нэгжийг улсын бүртгэлд бүртгэдэг болон тэдгээртэй харилцдаг төрийн байгууллагуудын хоорондын ажлын уялдаагүй байдал нь НББ-ийн тухай хуулийн хэрэгжилт, СТОУС-ын нэвтрэлтэд муугаар нөлөөлж байна.

Сангийн Яамны цахим тайлангийн нэгтгэлд хамрагддаг аж ахуйн нэгжийн тоог төрийн бусад байгууллагын бүртгэлтэй харьцуулахад дараах байдал ажиглагдаж байна.

Хүснэгт 3. Улсын бүртгэлд бүртгэлтэй болон Сангийн Яам, ТЕГ, ЭМНДЕГ-г тайлан тушааж, татвар, нийгмийн даатгалын тооцоо хийдэг ААН-ийн судалгаа

Он	Сангийн яам ¹		ОӨУБЕГ-г бүртгэлтэй ААН, байгууллага ²	ТЕГ-ын мэдээгээр ³					ЭМНДЕГ-д НДШ-ийн тайлан гаргадаг ⁴	
	Бүртгэлтэй	Цахим тайлангийн нэгтгэлээр		Бүртгэлтэй	ААНОАТ-ын тайлан гаргадаг	"Х" тайлан гаргадаг	Алдагалтай тайлан гаргадаг	ААНОАТ төлдөг		ХХОАТ-ын суутган тооцоо хийдэг
2014	96,558	79,075	133,259	105,755	79,169	28,372	15,136	38,736	86,598	34,996
2015	105,925	84,658	148,125	114,335	84,958	34,218	17,779	34,934	92,404	40,112

Эх сурвалж: 1. Сангийн Яамны санхүүгийн тайлангийн цахим нэгтгэлийн мэдээ
 2. ОӨУБЕГ-аас 2017 оны 2 дугаар сард СЯ-д ирүүлсэн судалгаа
 3. ТЕГ-ын 2017 оны 02/393 тоотой СЯ-д ирүүлсэн судалгаа
 4. ЭМНДЕГ-ын 2017 оны 30 тоотой СЯ-д ирүүлсэн судалгаа

Дээрх судалгаанаас үзэхэд, 2015 оны байдлаар Улсын бүртгэлд бүртгэлтэй аж ахуйн нэгжийн 57.1 хувь нь санхүүгийн тайлан гаргаж, татварын тооцоо хийдэг байна. Үлдэх 63.5 мянган аж ахуйн нэгж тайлан гаргадаггүй татварын тооцоо ч хийдэггүй ажээ.

Мөн татварын тайлан гаргасан 84.9 мянган аж ахуйн нэгжийн 34.2 мянга буюу 40.2 хувь "Х" тайлан гаргажээ. "Х" тайлан гэдэг бол хууль бус нэр томъёо бөгөөд үүний цаана татвар төлөхөөс зугтагч олон хуулийн этгээд нуугдаж байдаг нь 2015 оны "Ил тодын тайлан"² гэгчийн үеэр тодорхой болсон байдаг. 2015 оны байдлаар 34.9 мянга буюу нийт бүртгэлтэй аж ахуйн нэгжийн дөнгөж 23.6 хувь нь ААНОАТ төлсөн байна. 2015 онд татварын байгууллагатай 92.4 мянган аж ахуйн нэгж цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос ХХАОТ-ын суутган тооцоо хийсэн байв. Гэтэл эдгээрийн 43.4 хувь буюу 40.1 мянган аж ахуйн нэгж ЭМНДЕГ-тай НДШ-ийн тооцоо хийжээ.

Эндээс дараах байдал харагдаж байна:


- Өнгөрсөн 2015 онд 63.5 мянга буюу нийт аж ахуйн нэгжийн 42.9 хувь нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 болон 8 дугаар зүйлийн 8.1 зэрэг заалтыг буюу СТОУС-ын дагуу санхүүгийн тайлан гаргах үүргийг зөрчсөн байна.
- Нийт улсын бүртгэлд бүртгэлтэй аж ахуйн нэгжийн дөнгөж 23.6 хувь нь ААНОАТ, 27.1 хувь нь НДШ төлж байгаа нь улсын төсвийн их хэмжээний орлого алдагдаж байж болзошгүй юм.
- Дээр дурдсан асар их зөрчил жил бүр давтагдан гарч байхад төрийн байгууллагууд түүний дотор хуулийн этгээдийн улсын бүртгэлийн, татварын, нийгмийн даатгалын байгууллага болон аймаг, нийслэл, дүүргийн санхүү, төрийн сангийн хэлтэс тал талдаа анхаарч хамтран ажиллаагүй өдий хүрчээ.

² УИХ-аас 2015 оны 8 дугаар сард "Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай" хууль баталсан. Энэ хуулийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүний татвараас нуусан 34.7 их наяд төгрөгийн орлого ил болж, татвар төлөхөөс өршөөгдөж байв. Энэ үеэр аж ахуйн нэгжүүд 21,275 санхүүгийн тайлан; 89,394 татварын тайлан; 4,165 нийгмийн даатгалын тайлан; 8,140 гаалийн нөхөн мэдүүлэг шинээр гаргаж байжээ. Энэ арга хэмжээг "Ил тодын тайлан" гэж нэрлэдэг.

- г. ОӨУБЕГ, ТЕГ, ЭМНДЕГ-ууд хоорондоо мэдээлэл солилцдоггүй, хамтран ажилладаггүй байдал дээрх судалгаанаас тодорхой харагдаж байна. Хувь хүн болон ажил олгогч нь цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос НДШ төлөх тухай заалт Нийгмийн даатгалын хуульд байдаг. Гэтэл 2015 онд ТЕГ-т ХХОАТ-ын суутган тооцоо хийсэн 92.4 мянган аж ахуйн нэгж байснаас дөнгөж 40.1 мянга буюу 43.4 хувь нь НДШ-ийн тооцоо хийжээ. Хэрэв ЭМНДЕГ нь татварын байгууллагатай холбоотой мэдээлэл солилцдог байсан бол арай илүү үр дүнтэй ажиллаж болох байв.
- д. Монгол улсын аж ахуйн нэгжүүдийн дийлэнх олонх нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Нийгмийн даатгалын тухай болон ААНОАТ-ын тухай зэрэг олон хууль тогтоомжийг зөрчдөг байна.

Монгол улсын нийт аж ахуйн нэгжид СТОУС-ыг бүрэн нэвтрүүлэхэд саад болж байгаа хүчин зүйлийн талаар нягтлан бодогчид дараах саналтай байна.

Зураг 1. СТОУС-ыг бүх аж ахуйн нэгжид нэвтрүүлэхэд тохиолдож буй бэрхшээл



* Судалгаанд оролцсон 409 хүнээс хариулт өгсөн хүний тоо

Энэ судалгаанаас үзэхэд, нягтлан бодогчид, аудиторууд, бүртгэлийн мэргэжилтнүүдийн СТОУС-ын мэдлэг хангалтгүй, СТОУС-ыг мөрдүүлэх талаар төрийн захиргааны байгууллагын хяналт, мөн компаниудын засаглал сул байгаа нь СТОУС-ын нэвтрэлтэд бэрхшээл учруулдаг байна. Эдгээрийн дотор нягтлан бодогчдын мэдлэг сул байгаагаас СТОУС-ын нэвтрэлт удаан байгааг нягтлан бодогчдын 76.7 хувь нь хүлээн зөвшөөрсөн нь анхаарал татах асуудал мөн.


Нягтлан бодогчид СТОУС-ыг бүрэн нэвтрүүлэхийн тулд төрийн зүгээс зохион байгуулах шаардлагатай ажлын талаар дараах саналтай байна. Үүнд:

- Төрийн байгууллагын ажилтнуудын (бүртгэлийн мэргэжилтэн, татварын байцаагч, хяналтын ажилтан г.м) СТОУС-ын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх (94.3 хувь),

- Сангийн Яам, аймаг, нийслэл, дүүргийн төрийн сангийн хэлтсүүд НББ-ийн тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах (89.2 хувь),
- СТОУС-ыг орчуулах, үндэсний стандарт, тайлбар гаргах үүрэгтэй байнгын ажиллагаатай Стандарт тогтоогч байгууллагыг бий болгох (88.5 хувь),
- Төрийн бүх Яам, агентлагуудад салбарын ААН, байгууллагад СТОУС-ийг нэвтрүүлэх талаар үүрэг ногдуулах (82.4 хувь).


Судалгаанд оролцсон нягтлан бодогчид СТОУС-ын мэдлэгээ өөрсдөө үнэлсэн байдлыг доор үзүүлэв.

Зураг 2. Нягтлан бодогчид СТОУС-ын мэдлэгээ үнэлсэн байдал



Судалгаанд оролцогчдын 34.0 хувь (29.0+5.0) СТОУС-ыг сайн ба түүнээс дээш мэддэг гэсэн бол 66.0 хувь (46.1+19.9) нь дунд болон түүнээс бага мэднэ гэж хариулжээ. Мөн дээр өгүүлсэн СТОУС-ыг бүх аж ахуйн нэгжид нэвтрүүлэхэд тохиолдож буй бэрхшээл гэдэгт судалгаанд оролцогчдын 76.7 хувь нь “СТОУС-ын талаар нягтлан бодогчдын мэдлэг сул” гэж хариулсан байсан. Энэ нь СТОУС-ын талаар нягтлан бодогчдын мэдлэг хангалтгүй гэдгийг давхар нотолж байгаа юм. Нягтлан бодогчид СТОУС-ын урт, богино хугацааны ямар нэгэн сургалтад оролцсон байдлыг судлав.

Зураг 3. Сүүлийн 5 жилд судалгаанд оролцогчдын СТОУС-ын сургалтад хамрагдсан байдал



Энэ судалгааны мэдээлэл нь дээрх “Нягтлан бодогчдын СТОУС-ын мэдлэгээ үнэлсэн байдал” судалгааны дүнг дахин баталж байна. СТОУС-ын сургалтад 3-аас дээш удаа суусан хүмүүс түүнийг “бүрэн мэддэг” гэж, 2-3 удаа суусан нь “сайн мэддэг”, нэг удаа

эсвэл суугаагүй хүмүүс нь “дунд зэрэг”, “хангалтгүй” гэж хариулсан байна. Харин “СТОУС-ыг уншиж амжаагүй” гэсэн 28.6% дээр “хариулах боломжгүй” гэсэн 17.7%-ийг нэмбэл нягтлан бодогчдын 46.3% нь СТОУС-ыг бүрэн мэдэхийг эрмэлздэггүй байна. Тэдгээрийг судалж үзэхэд байгууллагын тооцооны нягтлан бодогч, жижиг компанийн нягтлан бодогчид ажээ. СТОУС-ын талаар нягтлан бодогчдын мэдлэг ийм байгаа нь анхаарал татах асуудал мөн. Иймээс маш системтэй арга хэмжээ авах шаардлагатай.

Нягтлан бодогчид СТОУС-ын тухай мэдээллийг олж авдаг эх сурвалжийг судлахад дараах байдалтай байв.

Зураг 4. Нягтлан бодогчид СТОУС-ын мэдээлэл олж авах эх сурвалжууд



Энэ судалгаанаас үзэхэд, нягтлан бодогчид богино хугацааны сургалт, интернетээс СТОУС-ын талаар илүү сайн мэдээлэл олж авдаг байна. Харин найз нөхөд, ном, гарын авлагаас харьцангуй бага мэдээлэл олж авдаг ажээ. СТОУС-ын талаар их дээд сургуулиас олж авсан мэдээлэлд 46.1 хувь сайн үнэлэлт өгсөн байхад 53.9 хувь нь дундаас доогуур үнэлгээ өгсөн байна. Энэ нь сургалтын хөтөлбөрт СТОУС-ыг илүү оруулах шаардлагатай болохыг өгүүлж байгаа хэрэг юм. Мөн богино хугацааны сургалт, гарын авлага, ном, интернетэд байршуулах материалын чанарыг сайжруулах нь зүйтэй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх, СТОУС-ыг нэвтрүүлэх ажил нь хоорондоо харилцан холбоотой дараах багц арга хэмжээг шаардаж байгаа юм.

1. Мэргэжлийн боловсрол, сургалт

а. Нягтлан бодогч мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиудтай холбогдсон дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх:

- Хувийн хэвшлийн бусад салбарын нарийн мэргэжлийн сургуулиуд багшийн хүрэлцээгүй байгаа хирнээ нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн бэлтгэх анги нээж, элсэлт авч, чанаргүй мэргэжилтэн бэлтгэж байгааг БСШУСЯ

- анхааралдаа авах нь зүйтэй. Цаашдаа судлах хичээл, оюутны тоо, багшийн тоо, тэдний мэргэжлийн бэлтгэлийн харьцааг агуулсан шаардлагыг тогтоож мөрдүүлэх нь зүйтэй.
- Нягтлан бодогч мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудад СТОУС-ыг практикт хэрэглэх арга, дадлага эзэмшүүлэх чиглэлээр мэргэжлийн хичээлийг СТОУС-тай холбох, мөн СТОУС-ын дадлагын лабораторитой болох.
 - Оюутны төгсөлтийн шалгалтад СТОУС-ыг оруулж, бүх сургуулиудын төгсөгчдөөс мэргэжлийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн комисс нэг тестээр шалгалт авдаг болох.
 - Одоогийн их, дээд сургуулийн практикт багш заасан оюутнаасаа өөрөө шалгалт аваад дүн тавьдаг, багш нарыг оюутанд ямар дүн тавьснаар нь үнэлдэг гажууд тогтолцоог засах нь зүйтэй.
 - СТОУС-ын талаар мэргэжлийн багш нарын мэдлэгийг сайжруулах, тэдэнд зориулсан тусгай хөтөлбөрийг боловсруулж мэргэжлийн байгууллагууд хэрэгжүүлэх.
 - Мэргэжлийн бүх сурах бичгийг СТОУС-ын хэрэглээтэй уялдуулах, энэ зорилгоор мэргэжлийн бүх сурах бичигт үзлэг хийх, зөвлөмж өгөх.
- б. Мэргэшсэн нягтлан бодогч, аудиторуудын мэдлэг чадвар гологдож байгааг өөрчлөх чиглэлээр дараах арга хэмжээ авах нь зүйтэй.
- Мэргэшсэн нягтлан бодогч, аудиторуудын шалгалтын өмнөх сургалтыг чанаржуулах, СТОУС-ыг бүрэн эзэмшсэн болох нь тогтоогдсоны дараа шалгалтад оруулдаг байх.
 - Мэргэшсэн нягтлан бодогч, аудиторуудын шалгалтын чанарыг сайжруулах.
 - 2017 оноос өмнө эрх авсан мэргэжлээрээ ажиллаж байгаа Мэргэшсэн нягтлан бодогч, аудиторуудыг СТОУС-ын мэдлэгийн байдлаар нь аттестатчилах.
- в. Мэргэжлээрээ ажиллаж байгаа нягтлан бодогчдын СТОУС-ын мэдлэг, чадварыг сайжруулах, тэдний мэдээлэл авах бололцоог нэмэгдүүлэх, мэргэжлийн ёс зүйг мөрддөг болгох чиглэлээр иж бүрэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Монгол хүн захиргааны мотивацийг хялбар хүлээж авдаг онцлогтой. Иймээс урамшууллын болон захиргааны мотивацийг хослуулан хэрэглэх нь зүйтэй.
- Нийт нягтлан бодогчдыг 2 жил тутам 30 кредит цагийн тасралтгүй боловсролын сургалтад оруулдаг болгох. Мэргэжлийн байгууллага жил бүрийн тасралтгүй боловсролын СТОУС, эрх зүйн шинэчлэлийн асуудлыг багтаасан хөтөлбөрийг зарладаг байх.
 - Мэргэжлийн чиглэлээр богино хугацааны сургалт явуулдаг байгууллагын хөтөлбөрт СТОУС-ыг хэрэглэх ур чадварыг нэмэгдүүлэх, салбарын онцлогоор төрөлжсөн байх зэрэг шаардлага тавьдаг болох.
 - 2014 онд батлагдсан “Мэргэжлийн ёс зүйн дүрэм”-ийг нийт нягтлан бодогчдод хүргэж ойлгуулах, хүлээн зөвшөөрүүлэх арга хэмжээ авах. Нягтлан бодогч мэргэжлийн оюутнуудад мэргэжлийн ёс зүйн дүрмийг ойлгуулах, хичээлийн хөтөлбөр, шалгалтын тестэд нь оруулдаг байх.

- Аж ахуйн нэгжийн удирдлагууд СТОУС-ыг ойлгосны үндсэнд үр шимийг нь хүртдэг, бас түүний хэрэглээг дэмждэг байна. Иймд компанийн засаглал, менежментийн чиглэлээр давтан сургалт явуулдаг байгууллага бүрийн сургалтын хөтөлбөрт СТОУС-ын хэрэглээний асуудлыг оруулдаг болох.
- Нийт нягтлан бодогчдыг тасралтгүй боловсролын сургалтад хамруулах, мэргэжлийн ёс зүйн байдалд хяналт тавих болон бусад олон талын ач холбогдлыг харгалзан мэргэжлээрээ ажиллаж байгаа нийт нягтлан бодогчдыг ойрын 3 жилд багтаан улсын бүртгэлд бүртгэж, мэдээлдэг болох.
- Нягтлан бодогчдыг СТОУС-ын мэдлэг болон түүнийг байгууллагадаа нэвтрүүлсэн ажлын үр дүнг харгалзан мэргэжлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгодог болох.
- СТОУС, тайлбар, гарын авлага, сургалтын материалыг төлбөргүй болон төлбөртэй хэлбэрээр байршуулдаг мэргэжлийн мэдээллийн вэб сайттай болох.

2. СТОУС-ын хэрэгжилтийг хангах талаар

- а. СТОУС-ыг орчуулах, тайлбар, гарын авлага гаргах, хэрэгжүүлэх чиглэлээр цогц арга хэмжээ авах нь зүйтэй.
 - СТОУС-ын орчуулгын чанарыг сайжруулах, тайлбар гарын авлага боловсруулах ажлын цар хүрээг харгалзан Сангийн Яамны дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хороог 7-оос доошгүй орон тооны ажилтантай болгож, хорооны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлдэг байх. Хэрэв төр үүнийг хариуцах боломжгүй гэж үзвэл стандарт батлахаас бусад үүргийг мэргэжлийн төрийн бус байгууллагад шилжүүлэх.
 - СТОУС-ыг орчуулж, хэвлэж, борлуулах нь нягтлан бодогчдод мэдлэг эзэмших хэрэгсэл болж чадахгүй байгааг харгалзан түүний тайлбар, хэрэглээний гарын авлагыг стандартын өөрчлөлт бүрээр гаргадаг байх.
 - Олон улсын стандартаар зохицуулагдаагүй Бэлчээрийн мал аж ахуй гэх мэт бизнесийн салбарт үндэсний стандартыг гаргаж мөрдүүлэх, бусад салбарт СТОУС-т нийцсэн үндэсний стандарт гаргах явдлыг дэмжих.
 - Стандартын хэрэглээний тайлбар, гарын авлагыг үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ гэх мэтээр салбар тус бүрээр гаргадаг байх.
- б. Аймаг, нийслэл, дүүрэгт ажилладаг бүртгэлийн мэргэжилтэн, улсын байцаагч нь цахим тайлангийн нэгтгэлээс өөр үүрэг багатай, СТОУС-ыг нэвтрүүлэх талаар аж ахуйн нэгжүүдтэй ажиллахгүй байна. Төрийн Яам, агентлагуудын зүгээс аймаг, нийслэл, дүүргийн бүртгэлийн мэргэжилтнүүдэд янз бүрийн давхар үүрэг хүлээлгэж ачааллыг нь нэмэгдүүлдэг байна. Мөн зарим дүүргийн бүртгэлийн мэргэжилтэнд 20.0 мянга гаруй аж ахуйн нэгж ногддог учраас ажиллах боломжийг нь хязгаарладаг байна. Иймээс дараах арга хэмжээ авах:
 - Нэг бүртгэлийн мэргэжилтэнд ногдох норм, ачааллыг тогтоож, шаардлагатай газарт орон тоог нь нэмэгдүүлэх.
 - Сангийн Яам жил бүр бүртгэлийн мэргэжилтэнд СТОУС-ыг нэвтрүүлэх чиглэлээр тодорхой даалгавар өгч дүгнэдэг байх.

3. Институци хоорондын уялдааг хангах талаар

Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийг хөгжүүлэхийн тулд тухайн мэргэжлийн үйл ажиллагаанд оролцогчдын зохицуулалтыг сайжруулах явдал чухал юм. Монгол улсад эрх зүйн орчин, институциудын тогтолцоо, зохицуулалт сул явж ирснээс төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн бага, үүнээс шалтгаалан СТОУС-ын нэвтрэлт бараг урсгалаараа явж ирсэн байна.

Төрийн байгууллагуудын мэдээлэл солилцож чадахгүй байгаа шалтгаан нь:

- Төрийн байгууллага тус бүрийн програм хангамжийн хэл, архитектур, дизайн, мэдээллийн гарцын стандарт өөр байгаагаас нэгдсэн системд орж харилцан ажиллах боломжгүй байгаа.
- Төрийн мэдээллийн харилцааг зохицуулах эрх зүйн орчин байхгүй учраас өөр өөрийн мэдээллийн санг бусад байгууллагад ашиглуулахыг хүсдэггүй.
- Ажлын уялдаагүй байдал, ажлын давхардал, хийдэл үүсдэг, нэг нэгэндээ чөдөр тушаа болдог, ингэснээр төрийн хүчийг сулруулж байдаг.

Энэ дутагдлыг засах арга нь Сангийн Яам, татвар, нийгмийн даатгал, хуулийн этгээдийн улсын бүртгэл зэрэг төрийн үйл ажиллагаа эрхэлсэн байгууллага, Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо, мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон Монгол улсын Санхүүгийн мэдээллийн нэгдсэн төвийг байгуулах явдал юм. Энэ нөхцөлд:

- Төрийн байгууллагын тооцоолох төвүүд хэвээр ажиллах,
- Тооцоолох төвүүдийн мэдээллийг цуглуулж нэг стандартад хөрвүүлж төрийн байгууллагуудыг иж бүрэн мэдээллээр хангах,
- Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн уялдааг хангах.

Монгол улсын санхүүгийн мэдээллийн нэгдсэн төвийн үйл ажиллагаа:

- Бизнесийн мэдээллийг цуглуулах.
- Нийт аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлангийн мэдээллийг цуглуулах.
- Аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа бизнес эрхлэгч иргэдийн борлуулах барааны нэр төрөл, тоо, үнийн мэдээллийг цуглуулах.
- Бизнесийн мэдээллийг боловсруулж хөдөлмөр, бараа, түүхий эд, материал, бэлэн бүтээгдэхүүн, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, техник хэрэгслийн гэх мэт арилжааны болон бодит үнийн мэдээллийг түгээх. Ингэснээр зах зээл дээрх бодит үнийн мэдээлэл дутагдсанаас болж хэрэгжихгүй байгаа олон СТОУС хэрэгжих боломж бүрдэх болно.
- Хөрөнгө оруулалтын төслүүдийн төсвийн бодит байдалд хянаж тавих, үнэн зөв мэдээллээр тухайн салбар, удирдлагыг хангах.
- Бизнесийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн компьютерийн программ хангамжийн боловсруулалт, стандартчилал, хэрэгжүүлэлтийн асуудлыг арга зүйн удирдлагаар ханган ажиллах.

ААН бүрт СТОУС-ыг нэвтрүүлэх гол арга нь тэднийг Нягтлан бодох бүртгэлийн бодлоготой болгох явдал юм. Гэтэл тэдний бүртгэлийн бодлого шаардлага хангахгүй байна. Иймд тэднийг бүртгэлийн бодлоготой болгоход чиглэсэн арга зүй, сургалт, зохион

байгуулалтын асуудлыг багтаасан томоохон хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байна.

СТОУС-ыг нэвтрүүлэх хууль, эрх зүй, зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал чухал байна.

- СТОУС-ыг нэвтрүүлэх талаар дээр дурдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэх үүднээс “Нягтлан бодох бүртгэлийн тухай” болон бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах.
- Санхүүгийн мэдээллийн төвийг байгуулах зорилгоор “Цахим засаг ба цахим мэдээллийн тухай” хуулийг гаргах.

Улсын төсвийн орлого нь бизнес эрхлэгчдийн татвараас бүрдэх бөгөөд төсвийн орлого их буюу бага байх нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын хэрэгжилтийн байдлаас үлэмж хамааралтайг Засгийн газар анхааралдаа авах нь зүйтэй. Энэ үүднээс Засгийн газар дээрх зөвлөмжийг тусгасан дунд хугацааны “Нягтлан бодох бүртгэл хөгжүүлэх хөтөлбөр” боловсруулж, батлан, хэрэгжүүлэхийг санал болгож байна.

